

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт

НАРИЙНТЭЭЛ СУМ, БАЙГУУЛЛАГЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА,
 АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2023.12.08

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл, тайлбар)
				он	түвшин		
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх.	1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг сумын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграмм суваг), мөн сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх.	Түгээсэн мэдээлэл, иргэдийн хандалтын тоо,	2022	Хандалтын тоо 1500 иргэн	2000 иргэнээс доошгүй	2023 оны 05 сард байгууллагын цахим хуудас болон пэйж хуудсаа Авлигын эсрэг “нэгдье” уриагаар ковер, фоноо сольж, сарын хугацаацаатай дээрх аянд нэгдэн, авлигын эсрэг ЗГ-ын болон АТГ-ын үйл ажиллагааг дэмжиж байгаагаа илэрхийлж ажилласан. Мөн Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, гарын авлага зэргийг сумын албан ёсны цахим хуудас болон сумын фэйсбүүк групп, төрийн байгууллагуудын сурталчилгааны самбарт байршуулах зэрэг боломжт хэлбэрээр олон нийтэд хүргэн ажилласан. Дээрх мэдээлэлд хандсан хандалтын тоо 126 Биелэлт 70

		1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг сум, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах.	Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан тоо	2022	1 ажил, арга хэмжээ зохион байгуулсан	Нөлөөллийн 1 ажил арга хэмжээ зохион байгуулах	2023 оны 10 дугаар сард "Төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөр"-өөр авлигыг эсрэг хэрэгжүүлж буй үйл ажилллагааг ард иргэдэд сурталчлан нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. Биелэлт 100
		1.3. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх.	Боловсруулсан материал, бэлтгэсэн гарын авлагын тоо	2022	300 ш тараах материал	1 доошгүй сурталчилгааны материал боловсруулах 1 доошгүй контент бэлтгэн түгээх	Төрийн байгууллагын албан хаагчид авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, авлигын эсрэг хуулийг сурталчилсан агуулга бүхий гарын авлага бэлтгэн тараасан. ЕБС-ийн сурагчдын дунд "Авлигын эсрэг-Бидний оролцоо" видео контентны уралдаан зарлаж шалгаруулан олон нийтэд түгээсэн. Тараах материал 250 ширхэг бэлтгэн тарааж, шалгарсан 3 контентийг бэлтгэн сумын албан ёсны цахим хуудсанд байршуулж нийтэд түгээсэн. Биелэлт 100
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах	2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	2022	12	Шинэ томилогдсон албан хаагчдын тоогоор	2023 онд шинээр томилогдсон төрийн байгууллагын нийт 13 албан хаагчид Авлигын эсрэг хуулийн сургалт зохион байгуулж хамруулсан. Биелэлт 100

		2.2. Төрийн албан хаагчдад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх талаар сургалт зохион байгуулах.	Хамтран ажилласан байгууллага, арга хэмжээний тоо	2022	-	2 доошгүй арга хэмжээ зохион байгуулах	ХАСХОМ гаргадаг албан хаагчдад ХАСХОМ гаргах аргачлал болон Авлигын эсрэг хуулийн талаар 2023 оны 01 сард цахим сургалт зохион байгуулахад 14 албан хаагч хамрагдсан. Сумын Насан туршийн боловсрол пэйж хуудас болон өөрийн цахим хуудсаар дамжуулан Авлигын эсрэг хуулийн зарим зүйл заалтуудыг бусад цахим хуудсанд байршуулан иргэдэд сурталчилан ажиллаж байна. ЕБС-ийн 8-12 дугаар ангийн 73 сурагчдад Авлигын эсрэг сургалт зохион байгуулж 73 хүүхэд хамруулсан. Төрийн албан хаагчдад 10 сард ХАСУМ гаргах, Мэдэгдэл тайлбар гаргах, 2022-2023 онуудад гарсаг Авлигын гэмт хэрэгний талаар 1 удаа сургалт зохион байгуулж 21 албан хаагчийг хамруулсан. Биелэлт 100
3.	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусган хэрэгжүүлэх.	Авлигаас урьдчилан сэргийлэх заалт тусгасан гэрээний тоо	2022	-	5 доошгүй гэрээнд тусгасан байна	ЗДТГ-тай төсөв хөрөнгө үарцуулж ажил гүйцэтгэх чиглэлээр хийгдэж байгаа /Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа бараа, ажил үйлчилгээ/ гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх заалтыг тусган гэрээ байгуулан хэрэгжүүлэн ажилласан. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 4 гэрээнд тусгасан. Биелэлт 70

		3.2."Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх.	Олон нийтийн хяналт хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, байгууллагын тоо	2022	-	Төрийн 9 байгууллага	"Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг ард иргэдэд сурталчлан ажилласан. Улсын болон орон төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудад хяналт тавих ажлын хэсгүүдэд иргэдийн төлөөллийн оруулж хэвшсэн. Биелэлт 70
4.	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах.	4.1. Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх.	Хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулсан тоо	2022	-	2 доошгүй хэлэлцүүлэг зохион байгуулсан байна	Сумын ЕБС, СӨББ-ууд эцэг эхчүүдийн дунд сургалтын орчинг сайжруулах чиглэлээр хэлэлцүүлэг 1 удаа, 2022-2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын үр дүн, иргэд олон нийтийн зүгээс гийн талаар сонсголыг сумын ИТХ-аас 1 удаа тус тус зохион байгуулсан. Төрийн байгууллага бүр байгууллагын үйл ажиллагааг байгууллагын цахим хуудас болон сумын цахим хуудсаар ил тод нээлттэй мэдээллэж, санхүүгийн үйл ажиллагааг шилэн дансны хуулийн дагуу мэдээллийг хуулийн дагуу байршуулж хэвшсэн. Сумын цахим хуудсыг шилэн дансны мэдээлэлтэй холбосон. Биелэлт 70

		4.3. Иргэд олон нийтээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2022	-	Сэтгэл ханамжийн судалгаа авах	Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, албан хаагчдын зан харилцаа, мэргэжлийн ур чадвар авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зэрэг үзүүлэлтээр Төрийн байгууллагуудын "Нээлттэй хаалганы өдөр"-өөр иргэд олон нийт үйлчлүүлэгчид, удирдлага, хамт олноос санал асуулга авч, гарсан санал, гомдолыг тухай бүрт нь шийдвэрлэн үйл ажиллагаандаа тусган ажилласан. Биелэлт 70
5.	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдаа танилцуулах.	Төлөвлөгөө болон тайлан боловсруулж, танилцуулсан аар	2022	АТҮХ, Авлигын эсрэг байгууллагын төлөвлөгөө, тайлан	Нийт алба хаагчдад танилцуулсан байна	2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд багтаан боловсруулж сумын албан ёсны цахим хуудсанд байршуулсан. Байгууллагын Авлигын эсрэг төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн явцыг байгууллагын албан хаагчдаа танилцуулсан. Биелэлт 70
		5.2. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусган, хэрэгжүүлэх.	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	2022	-	Тухай бүр	Авлигатай тэмцэх газраас ирсэн зөвлөмжийн хүрээнд ирсэн аймгийн Засаг даргын зөвлөмж чиглэлийг үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлж ажиллаж байна. Биелэлт 70

6.	Төрийн байгууллагуудын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах.	6.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжид заасан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө, орлогын мэдүүлгийн хугацаанд нь гаргаж хэвших.	Мэдүүлэг гаргасан тоогоор	2022	Хугацаа зөрчилтэй ХАСУМ, ХАСХОМ гараагүй	ХАСУМ, ХАСХОМ-ыг хугацаанд аа гаргасан байна.	2023 оны эхний 11 сарын байдлаар ХАСУМ хянуулах шаарлагатай 5 албан тушаалтны ХАСУМ-ыг АТГ-т хянуулж томилсон. Хуулийн дагуу мэдэгдэл тайлбарыг тухай бүр авч шийдвэрлүүлэн ажиллаж байна. 2021-2023 онд нийт 16 албан хаагчийн ХАСУМ-ийг АТГ-т хянуулж томилсон байна.
		6.2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд зориулсан контент бэлтгэн түгээх.	Нэвтрүүлэг контентийн тоо	2022	-	2 доошгүй контент, бэлтгэсэн байна.	2023 онд ЕБС-ийн сурагчдын дунд "Авлигын эсрэг-Бидний оролцоо" видео контентын уралдаан зарлаж шалгаруулсан. Шалгарсан 3 контентийг Сумын цахим сайтад байршуулж нийтэд түгээсэн.
		6.3. Авлигын эсрэг сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан хүүхэд залуучуудад хүргэх үйл ажиллагааг Хууль эрх зүйн хэлтэс, ЕБС-тай хамтран шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах.	Сургалтад хамрагдсан иргэн, хүүхэд залуучуудын тоо	2022	87	100	Сумын Засаг даргын Тамгын газраас насан туршийн боловсролын арга зүйчтэй хамтран "Авлигын эсрэг-Бидний оролцоо" сэдэвт сургалтыг 8-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж 73 хүүхэд, мөн шторкны уралдаан зохион байгуулж 3 контент ирснийг шалгаруулж Дурсамж, 120,0 мянган төгрөгөөр шагнаж урамшуулсан.
Биелэлтийн нийт дүн							82,8

ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН: ЗДТГ-ЫН ДАРГА

ХЯНАСАН: СУМЫН ЗАСАГ ДАРГА

Б.ИЧИННОРОВ.

Б.СУГАР.

